




БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

ХҮН БА ОРЧИН

III



Улаанбаатар хот
2020 он

Е.Батчулуун, Г.Баярмаа, Ө.Болорчимэг,
Т.Оюун, Д.Оюунчимэг, Э.Мөнгөнтулга,
Р.Нямхүү, У.Туяа, Ц.Пагмасүрэн,
С.Цогбадрах, М.Энхбаяр, А.Энхтогтох

ХҮН БА ОРЧИН



Ерөнхий боловсролын сургуулийн
3 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-822

Хүн ба орчин III: Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурах бичиг. / Энхтогтох А., ба бус; Ред. Мягмаржав У. -УБ.2014. -76х.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-47-5

ГАРЧИГ

3.1. ӨӨРИЙГӨӨ МЭДЬЕ	5
Миний бие	6
Миний хичээлийн хэрэглэл	25
Бид юу сурсан бэ?	28
3.2. ХАРИЛЦЪЯ, ХАМТАРЪЯ	29
Манай гэрийнхэн	30
Миний гэр орон	32
Бид юу сурсан бэ?	34
3.3. СУРГУУЛЬТАЙГАА ТАНИЛЦАЯ	35
Сургуулийн гадаад орчин	36
Сургуулийн дотоод орчин	41
Бид юу сурсан бэ?	47
3.4. ОРЧНОО АЖИГЛАЖ СУДАЛЪЯ	49
Орон нутаг ба хүмүүс	50
Орон нутаг ба байгаль	55
Бид юу сурсан бэ?	60
3.5. ЭХ ОРОН БА ДЭЛХИЙГЭЭ СУДАЛЪЯ	61
Эх орон	62
Эх дэлхий	67
Бид юу сурсан бэ?	72

ӨМНӨХ ҮГ

Хүүхдүүд ээ! Та нарт хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Энэ хичээлийн жилд та нар “Хүн ба орчин” хичээлээр

- Байгаль, нийгмийн юмс үзэгдлийг сонирхон судлах;
- Бусадтай харилцах;
- Эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, чадвар, дадал эзэмшиж зөв дадал хэвшилд суралцах болно.

Үүний тулд:

1. Юмс үзэгдлийг ажиглах, асуулт асуух, таамаглал дэвшүүлэх
2. Юуг, яаж судлахаа төлөвлөж, тэмдэглэл хөтлөх
3. Төлөвлөсний дагуу дасгал, даалгавар, сорил туршилтыг хийж гүйцэтгэх
4. Хийсэн ажлынхаа үр дүнг бусдадаа танилцуулж тайлбарлах гэсэн сурах арга барилын дөрвөн үйлд шатлан суралцана.

ТАНИХ ТЭМДЭГ



Судлах зүйлийн талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх



Юуг, яаж судлах ажлаа төлөвлөж тэмдэглэл хөтлөх




Дасгал, даалгавар, сорил туршилт хийж гүйцэтгэх



Хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулах

I ӨӨРИЙГӨӨ МЭДЬЕ



Миний бие
Миний хичээлийн хэрэглэл
Бид юу сурсан бэ?



АМЬД БИЕЙН ОНЦЛОГ ШИНЖ ЮУ ВЭ?



Чи олон хоногоор ус уухгүй мөн удаан хугацаагаар хөдөлгөөнгүй байж чадах уу?

Чадахгүй. Учир нь хүн хоол идэхгүй, хөдлөхгүй бол өсөж том болохгүй.












Амьд биеийн онцлог шинж юу вэ? Амьд биеийг хэрхэн ангилж болох талаар хамтран судалцгаая.




Дасгал 1. Дараах дасгалыг ажиглаад яагаад гэдгийг тайлбарлаарай.

Энэ бол миний дүү. Түүний нэрийг Баяр гэдэг.	Харин энэ бол миний тоглох дуртай тоглоом.	Яагаад вэ?
		
Би дүүгээ өлгийдөж чаддаггүй.	Харин би тоглоомоо өлгийдөж тоглоход амархан байсан.	
Миний дүү чихэр идэх дуртай.	Би тоглоомон хүүхэлдэй ба нохойдоо чихэр өгөхийг хүсдэг боловч тэд идэж чадахгүй юм.	
Миний дүү хоолондоо дуртай учраас өдөр ирэх тутам том болж байгаа.	Харин миний «Барби» хүүхэлдэй ба нохой хоол идэхгүй учраас том болохгүй байна.	
Миний дүү дөнгөж алхаж сурч байгаа. Тэр нэг удаа ширээ мөргөж унаад маш ихээр уйлсан.	Би тоглоомоо санамсаргүй ширээ мөргүүлээд унагаасан боловч тэр уйлаагүй.	

Дасгал 2. Зургийг ажиглаад амьд биеийн ямар онцлог шинжийг харуулсан болохыг тайлбарлаарай.




Дасгал 3. Зурагт өгөгдсөн амьд ба амьгүй биесийг ажиглаад, бүдүүвч ашиглан ангилаарай.



Дасгал 4. Аль нь амьд бие вэ? Яагаад вэ?




Дасгал 5. Дэлхий дээрх амьд бие хаана амьдардаг талаар ярилцаад дараах бүдүүвч зургийг гүйцээгээрэй.




Дасгал 6. Амьдрахад дараах амьд биесэд юу хэрэгтэй вэ?

- | | |
|------------|--|
| 1. Хүн | A. Хоол, ус, агаар |
| 2. Амьтан | B. Нар, хөрс, ус |
| 3. Ургамал | V. Хоол, ус, агаар, ундаа, тоглоом, зурагт |


Дасгал 7. Ургамал, амьтны зургийг ажиглаад ялгаатай ба төсөөтэй ямар зүйл ажигласнаа тайлбарлаарай.



Ургамал, амьтны өсөлт, хөгжил



Ургамал, амьтны хөдөлгөөн



Ургамал, амьтны хооллолт



Амьд бие хооллох, амьсгалах, хөдлөх, үржих, өсөх, цочрох шинж чанартай.

АМЬД БИЕ ЮУГААР ХООЛЛОДОГ ВЭ?



Амьд бие бүхэн хооллодог. Гэхдээ тэдгээрийн иддэг хоол өөр өөр байх уу?

Тийм шүү, хонь өвс ургамлаар хооллож байхад миний тэжээдэг нохой махаар хооллодог.



Амьтдын идэш тэжээлийг судалцгаая. Тэд юугаар хооллодог вэ?

.....	Шавж идэштэн

Амьтад идэш тэжээлээ олохын тулд хөдөлдөг, харин хүмүүс бид хөдөлмөрлөдөг. Хүний хооллолт амьтдынхаас юугаараа ялгаатай вэ? Хамтран судалцгаая. Хүн эрүүл хүнс хэрэглэхийн тулд:

- Хоол хүнсээ зөв сонгож хэрэглэнэ.
- Хоол хүнсээ ангилж хэрэглэнэ.
- Цагийн хуваарийн дагуу хооллоно.



Бид хоол хүнсээ сонгоход юуг анхаарах вэ?

Дасгал 1. Чи дэлгүүр болон худалдааны төвөөс хүнсний бүтээгдэхүүн худалдан авахдаа юуг анхаардаг вэ? Дөрвөлжин нүдэнд $\sqrt{\quad}$ тэмдэглэгээ хийнэ үү?

- Худалдан авах хүнсний бүтээгдэхүүний тоо ширхэгийг гаргана.
- Нэг бүрийн үнийг харна.
- Үйлдвэрлэсэн газрыг харна.
- Үйлдвэрлэсэн он сар өдрийг харна.
- Хугацаа дуусах он сар өдрийг харна.
- Хадгалах нөхцөлийг уншина.
- Ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг уншина.

Дасгал 2. Өөрийн сонгосон 2-3 хүнсний бүтээгдэхүүний шошгийг цуглуулж уншаад дараах хүснэгтэд тэмдэглэнэ үү? Тэмдэглэлээс юу мэдэж авснаа ярилцаарай.

Бүтээгдэхүүний нэр	
Үйлдвэрлэсэн газар	
Үйлдвэрлэсэн хугацаа	
Хадгалах хугацаа	
Хадгалах хугацаандаа хаана хадгалж хэрэглэх	

Дасгал 3. Бидний өдөр тутам хэрэглэдэг хоол хүнсийг өсөлтийн, илчлэгтэй, амин дэмтэй хоол хүнс гэж ангилдаг. Ямар хоол хүнс энэ ангилалд хамаарах талаар ярилцаарай.




Өсөлтийн хоол хүнс

.....



Илчлэгтэй хоол хүнс

.....



Амин дэмтэй хоол хүнс

.....

Дасгал 4. А.Б зургийг ажиглаад хоол хүнсийг дараах байдлаар хүснэгтэд ангилан бичээрэй

А.



Хоол хүнс	
Амьтны гаралтай	Ургамлын гаралтай

Б.



Хоол хүнс		
Хүнсний ногоо	Мах	Цагаан идээ

Дасгал 5. 7 хоногийн өглөөний хоолныхоо нэрийг бичээрэй.

Гарагс	Хоол хүнсний нэр
Даваа	
Мягмар	
Лхагва	
Пүрэв	
Баасан	
Бямба	
Ням	



Бидний өдөр тутмын хоол хүнс нь өсөлт хөгжилтөд нөлөөлөх ба эрүүл байх, биеийн эсэргүүцлийг сайжруулах ач холбогдолтой.

БИДНИЙ НЭГ ӨДРИЙН ХООЛ ХҮНС



Зохистой хооллолт гэж юуг хэлэх вэ?

Тогтмол цагт хооллохыг хэлдэг юм болов уу?



Бид зохистой хооллож чаддаг уу? Хамтран судалцгаая.




Дасгал 1. Тогтмол цагт хооллож хэвшүүлэх цагаа зурж тэмдэглээрэй. Зургийг харж хэзээ хэрхэн хооллох, ямар хоол хүнс хэрэглэх талаар ярилцаад бичээрэй.

Хэзээ хооллох вэ?	Зураарай	Ямар хоол хүнс хэрэглэх вэ?	Бичээрэй
Өглөө			
Бага үд			
Үд			
Их үд			
Орой			

Дасгал 2. Хэзээ сайн хооллох хэрэгтэйг бусдадаа тайлбарлаарай. Хүснэгтэн өгөгдлийг дугуй диаграммд тэмдэглээрэй. Яагаад гэдгийг тайлбарлаарай.

Өглөө
Бага үд
Үд
Их үд
Орой



Дасгал 3. Найзаасаа өглөөний цайгаа уусан эсэх, ямар хүнсний бүтээгдэхүүнд дуртай болохыг нь асууж хүснэгтэд тэмдэглээрэй.


Нэр	Өглөөний цайгаа уусан эсэх	Ямар хүнсэнд дуртай болох

Дасгал 4.

Дараах мэдээллийг уншаад хэнд ямар зөвлөгөө өгөх хэрэгтэйг төлөвлөөд хэрэгжүүлээрэй.

Өглөөний цайгаа уухын ач тус:

- Тогтмол унд ууж хэвших нь хоолны дуршлыг сэргээх хамгийн сайн арга.
- Ядаргаа, нозоорсон нойрмог байдлаас гаргана.
- Эрч хүчийг нэмэгдүүлж, сэтгэл санааг өөдрөг болгоно.
- Анхаарал төвлөрлийг дээшлүүлж, оюун ухааныг сэргээнэ.



Чихэрлэг хүнсний бүтээгдэхүүний сөрөг нөлөө:

- Биеийн эсэргүүцлийг сулруулна.
- Анхаарал төвлөрөх чадвар буурна.
- Баашлах, олон ааш гаргах зэргээр сэтгэцэд нөлөөлнө.
- Арьс хуурайшиж харшил үзүүлнэ.
- Шүд цоорно.
- Биеийн жинг нэмэгдүүлж таргалуулна.



Зохистой хооллохын тулд дараах зүйлийг анхаараарай.

- Цагаар хооллох
- Олон төрлийн хоол хүнс хэрэглэх
- Илчлэгтэй хоол хүнсийг зөв хэрэглэх

СУРГУУЛИЙНХАА ҮДИЙН ЦАЙНЫ ХООЛНЫ ЦЭСИЙГ СУДАЛЪЯ



Сургуулийнхаа үдийн цайны цэстэй танилцаж, мэдээлэл бэлтгэе.



Үдийн цайны хүнсний бүтээгдэхүүний нэрийг бичээд хүнсний ямар төрөлд хамрагдаж байгааг судалцгаая.



Дасгал 1. Үдийн цайны цэстэй танилцаад хоолны нэрийг бичнэ үү.

Гараг	Хоол хүнсний нэр
Даваа	
Мягмар	
Лхагва	
Пүрэв	
Баасан	
Бямба	
Ням	

Дасгал 2. Үдийн цайнд хэрэглэдэг гурилан бүтээгдэхүүний нэрийг бичээрэй.

.....

.....

Дасгал 3. Үдийн цай, хоолны цэсэд хийсэн мэдээллээ ашиглан хүнсний бүтээгдэхүүнийг ангилаарай.

Өсөлтийн хүнс	Илчлэгтэй хүнс	Амин дэмтэй хүнс

Дасгал 4.

1. Үдийн цай, хоол хүнсний бүтээгдэхүүнд өсөлтийн хүнс, илчлэгтэй хүнс, амин дэмтэй хүнсийг хэр зэрэг хэрэглэж байгаа талаар ярилцаарай.
2. Сургуулийн үдийн цай, хоолны амт, чанар ямар байдаг вэ? Чамд ямар хүнс илүү таалагдсан бэ? Яагаад вэ?
3. Бидэнд эрүүл хүнсний бүтээгдэхүүн сонгон хэрэглэх нь яагаад чухал вэ?



Бид өдөр тутмын хоол хүнсэндээ:

1. Өсөлтийн хүнс: өндөг, лууван, сүү
2. Илчлэгтэй хүнс: мах будаа, талх
3. Амин дэмтэй хүнс: жимс, ногоо хэрэглэж зөв зохистой хооллох дэглэм баримталж сурах нь эрүүл амьдрахын үндэс болно.

ХООЛ ХҮНСИЙГ БОЛОВСРУУЛАХАД ШҮД ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?



Амьтдын шүд өөр байдаг гэж би сонссон, яагаад өөр байдаг юм бэ?

Тэдний иддэг хоолтой холбоотой байх аа.




Шүд ямар үүрэгтэй болохыг мэдэж авъя
Шүд хоолыг бутлахаас гадна өөр ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?



Туршилт 1. Талх идээрэй.

- Талхыг амандаа хийсэн сурагчдыг хараарай. Гадаад төрхөд ямар өөрчлөлт гарсан байна вэ?
- Талх амандаа хийгээд буталж жижиглэхээс өмнө хоорондоо хос хосоороо ярилцаарай. Хэл ярианд ямар өөрчлөлт гарч байна вэ?
- Дараа нь шүднийхээ тусламжтайгаар талхыг тасдаж, жижиглэн бутлаарай. Ямар шүд оролцож байна вэ?

Дээрх туршилтыг гүйцэтгэсний дараа шүд ямар үүрэгтэй болох талаар ярилцаад дараах бүдүүвчид тэмдэглээрэй.



Дасгал 1. Хүн амьдралдаа 2 удаа шүдэлдэг. Хамгийн анхны шүд 4-6 сартайд ургаж 3 настайдаа нийт 20 шүдтэй болдог. Үүнийг сүүн шүд гэнэ. Харин 5-7 наснаас сүүн шүд байнгын шүдээр солигдож 12-13 насанд нийт 28 шүдтэй болно.

Дасгал 2. “Зажилж идвэл хоол, залгиж идвэл хор” гэдэг өгүүлбэрийн утгыг тайлбарлаарай.

Дасгал 3. Амьтдын идэш тэжээл өөр өөр байдаг тул тэдний шүдний бүтэц ялгаатай байдаг. Доорх зургийг ажиглаад ямар идэш тэжээлтэй амьтдын шүд болохыг тохируулаарай. Яагаад вэ?

1. Араа шүд



2. Соёо шүд



3. Үүдэн шүд



А. Чоно (махан идэштэн)

Б. Морь (өвсөн тэжээлтэн)

В. Туулай (ургамлын үндсээр хооллодог-мэрэгч)

Шүд нь хоол тэжээлийг жижиглэж буталдаг, мөн хүний хэл яриа, гоо сайханд нөлөөлдөг.

АМЬД БИЕ ЯАГААД ХӨДӨЛДӨГ ВЭ?



Амьд бие бүхэн хөдөлдөг боловч хөдөлгөөн нь өөр өөр байдаг. Яагаад вэ?

Морь алхана, шогшино давхина. Харин загас сэлдэг. Амьтдын хөдөлгөөн яагаад өөр өөр байдгийг асууж мэдэж авъя.



Амьд бие хоол тэжээлээ олохын тулд хөдөлдөг. Өөр шалтгаан байдаг эсэх, амьд биеийн хөдөлгөөний ялгаатай байдлыг хамтран судалцгаая.








Туршилт 1. Хэрэглэгдэх зүйлс: Шаар

Анхаарах зүйл: Үлээсэн шаарыг хүчтэй шахаж хагалахгүй байх




Туршилт хийх дараалал

- Сурагчид хосоор ажиллана.
- Үлээсэн шаараа бие биенийхээ нүүрэнд хүргэнэ.
- Энэ үед ямар хариу үйлдэл үзүүлж байгааг ажиглаарай.
- Энэ жишээг ашиглан амьд бие яагаад хөдөлдөг болох хоёр дахь шалтгааныг тайлбарлаарай.

Дасгал 1. Амьтдын хөдөлгөөний төрлийг нэрлээд хөдөлгөөнд биеийн аль хэсэг оролцож байгааг тайлбарлаарай.

Асуулт					
Яаж хөдөлдөг вэ?
Хөдөлгөөнд биеийн ямар хэсгүүд оролцдог вэ?

Дасгал 2. Зургийг ажиглаад ургамал, амьтан, хүний хөдөлгөөний ялгааг харьцуулаарай.

Асуулт			
Яагаад хөдөлсөн бэ?.
Ямар хөдөлгөөн хийсэн бэ?

ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨН



Хүн яагаад олон янзын хөдөлгөөн хийдэг бэ?

Хоолоо олж идэх, сайхан амьдрахын тулд юм болов уу?




Хүн ихэвчлэн ямар төрлийн хөдөлгөөн хийдэг вэ? Өөрсдийн мэдэх жишээгээр ярилцъя.



Дасгал 1. Зургийг ажиглаж, хүмүүс ямар төрлийн хөдөлгөөн хийж байгааг найздаа тайлбарлаарай.



Дасгал 2. Бүдүүвчийг дэвтэртээ зураарай. Хөдөлгөөний төрөлд тохируулан өөрийн мэдэх жишээг дэвтэртээ бичээрэй.



Хүний хөдөлгөөн нь хэрэгцээ, зорилгоороо ялгаатай байна. Үүнд:

- Ахуй амьдралын хөдөлгөөн (мод хөрөөдөх, ус зөөх, шал угаах, ногооны талбайд ажиллах)
- Эрүүл мэндэд чиглэсэн хөдөлгөөн (аялал зугаалгаар явах, дугуйгаар аялах)
- Бие бялдарыг хөгжүүлэхэд чиглэсэн хөдөлгөөн (усанд сэлэх, гүйх)
- Биеийн тамирын хөдөлгөөн (Сагс, уран гимнастик зэрэг спортын төрлөөр хичээллэх)

ХООЛ ХҮНС БА ХӨДӨЛГӨӨН



Хүмүүсийн биеийн жин харилцан адилгүй байдаг. Энэ нь юутай холбоотой вэ?


Ангийнхантайгаа хамтран судалж ярилцъя.



Хүмүүсийн биеийн жин өөр байдгийн учир шалтгааныг судалцгаая.




Дасгал 1. А. Б. В зургийг ажиглаж харьцуулаарай. Ямар ялгааг та нар мэдэж авсан бэ?



Дасгал 2. Зураг ажиглаад хийсэн дүгнэлтдээ үндэслэн дараах асуултад хариулж бичээрэй.

- Хоол идээд, дасгал хөдөлгөөн багатай байвал биеийн жин ямар байх вэ?
- Хэрвээ чи хоол бага идээд, хөдөлгөөн ихтэй байвал чиний биеийн жин ямар байх вэ?
- Идсэн хоол, хөдөлгөөний хэмжээ зохистой байгаа тохиолдолд биеийн жин ямар байх вэ?

Дасгал 3. Гурвалжин дүрсийг дэвтэртээ зураад дараах хүнсний бүтээгдэхүүний нэрийг зөв байрлуулж бичээрэй.



Их хэмжээгээр хэрэглэх хүнс: хүнсний ногоо, жимс, цагаан идээ
Дунд зэрэг хэмжээгээр хэрэглэх хүнс: будаа, талх, гоймон
Бага хэмжээгээр хэрэглэх хүнс: өөх тос, давс, сахар



Эрүүл хүнс, идэвхтэй хөдөлгөөнийг хүн бүр эрхэмлэдэг. Төрөл бүрийн хүнсийг тохирох хэмжээгээр хэрэглэж, дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшвэл эрүүл мэндэд ач тустай.

АМЬД БИЕ ХЭРХЭН ӨСДӨГ ВЭ?



Амьд бие бүхэн өсөх үү?

Амьд бие өсдөг бол бас хөгждөг байх.



Амьд биеийн үр төл, тэдгээрийн өсөлт хөгжил болон наслалт ижил байх уу? Өөр байх уу?

Мэдээллийг хаанаас цуглуулж авах вэ? Төлөвлөөрэй.

Хэнээс асуух вэ?



Юу асуух вэ?



Юуг мэдэж авах вэ?




Дасгал 1. Дараах амьд бие ямар үр төл төрүүлэх вэ? Туулайн үр төлийг юу гэж нэрлэдэг вэ? Өөрийн мэддэг зүйлээ найздаа ярьж өгөөрэй.

- | | |
|-----------|---------------------------|
| 1. Загас | А. Өндөглөнө |
| 2. Тахиа | Б. Түрс шахна. |
| 3. Туулай | В. Амьд зулзага төрүүлнэ. |

Дасгал 2. Амьд бие өсөж том болоход нөлөөлдөг зүйлүүд юу вэ? Ярилцаад нэрлэж бичээрэй. Яагаад гэдгийг тайлбарлаарай.

Дасгал 3. Мэлхий болон хүний өсөлт хөгжил ямар ялгаатай байна вэ? Зургийг харж ярилцаарай.



Дасгал 4. Дээрх хүүхэд насны ангиллын зургийг хараад ямар нас болохыг хүснэгтэд нөхөж бичээрэй.

Хүүхэд нас	10 хоног	1 нас хүртэл	1-3 нас	4-5 нас	6-17 нас
.....




Зарим амьд бие амьд үр төл төрүүлдэг. Ийм амьд бие шууд өсөж, хөгждөг. Харин зарим амьд бие өндөг гаргана. Өндөг ба эхийн хэвлийгээс гарсан төл эх биетэйгээ огт төсгүй байж болно.

ӨСӨЖ ТОМ БОЛОХЫН БАЯР



Бага насныхаа зургийн цомгийг ажиглаж хэр том болсноо харьцуулаарай. Чи хэр өссөн байна вэ? Хамтран ярилцаарай.




Биеийн өндөр, жинг хэмжих багажийг ашиглан хэмжилт хийж тэмдэглэе.

Биеийн өндөр, жинг хэмжихдээ юуг анхаарах вэ?

- Эмнэлгийн болон баталгаат жин, өндөр хэмжигчийг хэрэглэнэ.
- Хөл нүцгэн зогсоно.
- Тэгшхэн зогсоно.
- Хэмжилтийн тоог зөв харж уншиж тэмдэглэнэ.



А




Б




Дасгал 1. Найзтайгаа хамтран биеийн өндөр, жингээ хэмжиж тэмдэглээрэй.

Он. сар. өдөр				
Сурагчдын нэр	Т.Анар	С.Наран	Н.Сүхээ	Ж.Туяа
Өндөр (см)	116	118	118	115
Жин (хүнд, хөнгөн) кг	18	20	16	21

Дасгал 2. Тэмдэглэлээ багана диаграммаар илэрхийлж, найз нөхдийнхөө өндөр, биеийн жинг харьцуулан дүгнэлт гаргаарай.





Хэн нь өндөр ба нам байна вэ?
Хэн нь хүнд ба хөнгөн байна вэ?




МИНИЙ БИЕ

Биеийн жин (хүнд, хөнгөн) кг



Дасгал 3. Чи өсөж том болж байгаагаа яаж мэдсэн бэ? Аль нь биеийн өсөлтөд, аль нь биеийн хөгжилд гарсан өөрчлөлт вэ?



Миний өндөр

.....



Миний гар

.....



Миний хүч

.....



Миний оюун ухаан



.....

Дасгал 4. Чиний өсөлтөд дараах мэдээллээс аль нь нөлөөлсөн гэж бодож байна вэ?

1. Өдөр тутам жимс, хүнсний ногоо хэрэглэх
2. Дасгал хөдөлгөөн хийх
3. Сүү, цагаан идээ хэрэглэх
4. Явган явах, гүйх зэрэг хөдөлгөөнтэй байх
5. Бүгд

Дасгал 5. Дөрвөлжин шугамтай цаасан дээр гараа сарвайлган тавьж харандаагаар тойруулж зураарай.

А. Таван хурууныхаа дүрсийн уртыг шугам ашиглан хэмжиж тэмдэглээрэй.




Гарын хуруу	Хэмжилтийн урт (см)	
	Баруун	Зүүн
Эрхий		
Долоовор		
Дунд		
Ядам		
Чигчий		

Б. Бидний гарын 5 хурууны уртын хэмжээ нь боловч баруун, зүүн гарын хурууны уртын хэмжээ байна.

Дасгал 6. Гарын хуруунууд яагаад өөр өөр урттай байдаг вэ? Туршаад үзээрэй.

- Тавагтай үрлийг өнгөөр нь ялгаарай.
- Үрлээ дахин холиод 2 дахь удаагаа ялгахын өмнө эрхий ба чигчий хурууг цаасаар ороож туузан наалтаар наан уртасгаарай. Аль тохиолдолд үрлийг ялгахад хэцүү байсан бэ?
- Гарын хуруу өөр өөр урттай байдгийн учрыг тайлбарлаарай.



Дасгал 7. Өсөж том болсноороо бид юуг хийж чаддаг болсон бэ?

- Бүдүүвчид бичээрэй.

Бие бялдрын хөгжил

Оюун ухааны хөгжил

.....

.....

- Бие өсөж том болохын баяр юу вэ? Сэтгэгдлээ бичээрэй.



Эрдэм ном сурч
байна.



Найздаа тусалж
чаддаг болсон.



Олон ажил хийж
чаддаг болсон.



Хүний биеийн өсөлт хязгаартай. Хүний өсөлт 0-25 насанд явагддаг. Хүний өсөлт нь хөгжилтэй салшгүй холбоотой. Хүн өсөж том болохын хэрээр бие бялдар, оюун ухаан хөгжиж байдаг.

ХАРАХ БА ХҮРЭЛЦЭХ МЭДРЭМЖ



Халуун, хүйтэн, өвдөлт, шүргэлтийг яаж мэдэрдэг вэ?

Туршилтаар судалцгаая



Хэрэглэгдэх зүйлс:

1. Баримлын шавар
2. Хуванцар хутга
3. Гарын алчуур
4. 40*40 хэмжээний картон цаас



Туршилт 1.

1. Баримлын шавраар хөдөлмөрийн багаж хийгээрэй.
2. Хийсэн багажаа ширээн дээр байрлуулж нэрийг нь дэвтэртээ бичээрэй.
3. Дараа нь нүдээ боогоод тэмтэрч үзээрэй.
4. Багажийг хараад нэрлэх, нүдээ боогоод тэмтэрч нэрлэхэд ямар хугацаа зарцуулагдсан бэ? Ялгаатай байна уу?
5. Дараах хүснэгтэд хугацааг тэмдэглээд тайлбарлаарай.

Харж нэрлэхэд зарцуулсан хугацаа	Харахгүйгээр нэрлэхэд зарцуулсан хугацаа
..... МИНМИН

Дасгал 1. Ширээн дээр багшийн бэлтгэн байрлуулсан юмсыг гараараа тэмтэрч үзээрэй. Юу мэдэрснээ дэвтэртээ бичээрэй.

Дасгал 2. 1 - 6 - г гүйцэтгээд дүгнэлт гаргаарай.

1. Хүний хараанд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийг бичээрэй.
2. Уншиж, бичиж буй зүйлээс нүд хүртэлх зай ямар байх нь тохиромжтой вэ?
3. Ном унших, бичихдээ 10-20 минут завсарладгийн учир юутай холбоотой вэ?
4. Гэрийн хурц гэрэлд бүрхүүл хийдэг, Ямар учраас вэ?
5. Харааг гэмтээж болзошгүй ямар зүйлс байна вэ?
6. Нүдний дасгал хийдгийн учир юу вэ? Ямар ач холбогдолтой вэ?



АМТЛАХ МЭДРЭМЖ



Би чихэр идэх дуртай. Яагаад гэвэл амттай.

Чихэр амттай ч шүдэнд халтай учраас идсэний дараа шүдээ угаах хэрэгтэй.



Чихэр болон бидний иддэг хүнсний бүтээгдэхүүн бүр өөр өөр амттай. Дараах бүтээгдэхүүн ямар амттай вэ?

Туршилт 1.

Хэрэглэгдэх зүйлс: Нунтаг цагаан давс, элсэн чихэр, лимоны хүчил

- Хүний хэлний аль хэсэг ямар амтыг мэдэрч байгааг хэрхэн ялган танихаа төлөвлөж, таамаглал дэвшүүлээрэй.
- Дараа нь хэлний үзүүр хэсэгт хүргэснээс хойш хэдий хугацаанд амтыг мэдэрсэн болохыг багшийн тусламжтайгаар хүснэгтэд тэмдэглээрэй.

	Давс	Элсэн чихэр	Лимоны хүчил
Ямар амтыг мэдэрсэн бэ?
Ямар хугацааны дараа амтыг мэдэрсэн бэ?

Дасгал 1. “Хүнсний зах” дүрд тоглоцгооё

- Ангидаа хүнсний зах байгуулна.
- Сурагчид ямар хүнснийг ихээр сонгож, худалдан авсан бэ?
- Ямар хүнснийг ихээр хэрэглэвэл эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй вэ?

Сонгосон тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл												
Сүүн бүтээгдэхүүн												
Гурилан бүтээгдэхүүн												
Чихэрлэг бүтээгдэхүүн												
Давсалсан самар												
Хийжүүлсэн ундаа												
Ус, рашаан												



Бидний хэл халуун хүйтэн, хатуу зөөлөн, гашуун, исгэлэн, чихэрлэг, давслаг амтыг мэдэрдэг. Хэлний хэсгүүд харилцан адилгүй байдлаар амтыг мэдэрнэ. Мөн хоол хүнснийг боловсруулах болон хэл ярианд чухал үүрэгтэй.

СОНСОХ БА ҮНЭРЛЭХ МЭДРЭМЖ



Бусдыг сонсоод хариу үйлдэл хийцгээе.



Туршилт 1. Багшийн хэлэх зааврыг анхааралтай сонсож хөдөлгөөн хийцгээе.

Анхаарах зүйл: Бусдаасаа зөрж алдсан сурагчид суудалдаа сууна. Хөдөлгөөн хийж дууссаны дараа хэдэн сурагч суусан болохыг ажиглаарай. Туршилтын үр дүнд үндэслэн дараах асуултад хариулаарай.

1. Ямар мэдрэхүйгээ ашиглан дээрх хөдөлгөөнийг хийсэн бэ?
2. Хэдэн сурагч суусан байна вэ? Тэднээс яагаад алдсан бэ?

Туршилт хийх дараалал:

- Ширээнийхээ дэргэд гарч зогсоорой.
- Баруун гараа дээш өргөөрэй.
- Зүүн гараа урагш өргөөрэй.
- Хоёр гарын хөдөлгөөнийг нэг, хоёр гэсэн командын дагуу ээлжлэн өргөх хөдөлгөөн хийгээрэй.

Туршилт 2. Багш хийх хөдөлгөөнийг дагаад хийгээрэй.

Мөн бусдаасаа зөрж алдсан сурагчид суудалдаа сууна. Хөдөлгөөн хийж дууссаны дараа хэдэн сурагч суусан болохыг ажиглаарай. Сонсоод дасгал хийх, хараад дасгал хийх хоёрт ялгаа байна уу? Ярилцаарай.



Бид бусадтай харилцах явцад мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар мэдээллийг хүлээн авч хариу үйлдэл үзүүлдэг. Амьд бие чихний тусламжтайгаар дуу чимээг мэдэрч аюулаас биеэ хамгаалж чадна. Удаан хугацаанд үргэлжлэх шуугиан, хэт чанга дуу чимээ сонголд муу нөлөөтэй.

Туршилт 3. Багш “шөнө” гэж хэлэхэд сурагчид нүдээ аниад толгойгоо ширээн дээрээ наалдуулна. Багш янз бүрийн үнэртэй зүйлсийг ашиглана. Ангид юу үнэртэж байна вэ? Таагаарай

Дасгал 1. Дээрх үйлийг хийсний дараа дараах асуултад хариулаарай.

1. Юу мэдэрсэн бэ?
2. Дээрх үнэрийг яаж мэдсэн бэ?

Амьд бие хамрын тусламжтайгаар үнэрийг ялган таних бөгөөд үнэрийг мэдрэх чадвар амьд бие бүрт харилцан адилгүй байдаг.

ЯАЖ ХЭМЖИХ ВЭ?



Бид өмнөх ангиудад өөрийн хичээлийн хэрэглэл болон ангид байдаг сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хэрэглэх, хадгалах тухай үзсэн.

Туршилт хийхэд зайлшгүй ашигладаг зарим сургалтын багаж хэрэгсэлтэй танилцацгаая.



Хэрэглэгдэх зүйлс:

- Шилэн аяга
- Ус
- Шугам
- Өсгөгч шил
- Цаг
- Хөвөн
- Буудайн үр
- Халуун хэмжигч багаж (термометр)
- Цаг тооны бичиг
- Зургийн аппарат



Туршилт 1.

Туршилт хийх аргачлал

1. Чийгтэй хөвөн дэвссэн шилэн аяганд хэдэн ширхэг буудайн үрийг 2-3 см зайтай тараан байрлуулаарай.
2. Дараа нь шилэн аяганы амсрыг нь гялгар уутаар бүрхэх ба уутыг нүхэлж халуун хэмжигч багажийг шилэн аяганд дүрж байрлуулна.
3. Халуун хэмжигч багажийн заалтыг шилэн аяганы гаднаас харахад харагдаж байхаар байрлуулна.
4. Бэлэн болсон үрээ гэрэлтэй, дулаан байранд (цонхон дээр) тавиарай.
5. Өдөр бүр тогтсон цагт шилэн аяган доторх халууныг хэмжиж тэмдэглэнэ. Ангийн агаарын хэмээс ямар ялгаатай байгааг харьцуулан зөрүүг тэмдэглээрэй.
6. Мөн үрийн ургалтыг ажиглана. Ямар өөрчлөлт гарч байгааг өдөр бүр ажиглаж тэмдэглээрэй.
7. Үр соёолж эхэлнээс хойш өдөр бүр тогтсон цагт өндрийг нь хэмжээрэй
8. Үр дүнг баганан диаграммаар илэрхийлээрэй.
9. Навчийн судлыг ажиглаж дэвтэртээ зураарай.



Дээрх туршилтыг хийж үр дүнгээ гаргахад бид ямар багаж хэрэгслийг яаж ашиглах вэ? Төлөвлөөрэй.

1. Шугам




Ихэнх тохиолдолд шугамаар уртыг хэмждэг боловч бид эгц шулуун зурах зорилгоор ч бас ашигладаг.

2. Термометр




Термометрийн заалтыг зөв харж тэмдэглэх нь чухал. Термометрийг унагаж хагалахаас болгоомжлоорой.

3. Өсгөгч шил



Ихэнх өсгөгч шил бодит байдлаас 2-25 дахин их өсгөдөг. Бидний нүдээр харагдахгүй зүйлийг өсгөгч шил ашиглан харна.

4. Зургийн аппарат





Ажигласан зүйлээ баримтжуулах зорилгоор зураг авч болно.

5. Цаг тооны бичиг, цаг

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Ургамлын өндөр (см)							

Сар, өдөр, хугацааг тэмдэглэх зорилгоор ямар ч судалгаанд хэрэглэдэг.

Туршилтын үр дүнг дараах хүснэгтэд тэмдэглээрэй.

Асуулт	Сар. өдөр. цаг	Үр дүн																				
Хэдэн ширхэг үрийг хэдэн сантиметр зайтай байрлуулж үрслүүлсэн бэ?																						
Хаана, ямар газар байрлуулж ажигласан бэ?																						
Үрийн бүтэц, ургалтад ямар өөрчлөлт гарч байгааг тэмдэглээрэй.																						
Шилэн аяган доторх халууны хэм хэд байсан бэ?	Өдөр бүр 12 цагт харж тэмдэглэнэ.	<table border="1"> <tr> <td>Өдөр</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>t°</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table>	Өдөр										t°									
Өдөр																						
t°																						
Тасалгааны агаарын хэм хэд байсан бэ?	Өдөр бүр 12 цагт харж тэмдэглэнэ.	<table border="1"> <tr> <td>Өдөр</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>t°</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table>	Өдөр										t°									
Өдөр																						
t°																						
Температурын зөрүүг олоорой.		<table border="1"> <tr> <td>Өдөр</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Зөрүү</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table>	Өдөр										Зөрүү									
Өдөр																						
Зөрүү																						
Ямар нөхцөлд үр ургасан вэ?																						
Соёололтын уртыг шугамаар хэмжиж баганан диаграмм байгуулаарай.		<div style="display: flex; align-items: center;"> <div style="margin-right: 20px;"> <p>Өндөр (см)</p>  </div> <div>  </div> </div>																				
Навчийн судлыг ажиглаад зураарай. Ямар судалтай болохыг багшаасаа асууж тэмдэглээрэй.																						


t° -Шилэн аяган доторх халуун болон тасалгааны агаарын хэмийг тэмдэглээрэй.




Хүмүүс олон янзын хэмжих багажийг зохион бүтээж ашиглаж байна. *Уртыг хэмжих багаж* - төрөл бүрийн шугамыг ашиглан урт өргөн, зузаан нимгэн, мөн муруй шугамын уртыг олж болно. Хэмжилт хийхдээ шугамын хуваарийг эгц харна.

Хугацааг хэмжих багаж - хугацааг хэмжихдээ төрөл бүрийн цагийг хэрэглэсээр ирсэн. *Халуун хэмждэг багаж* - термометр. Термометрийн заалтыг эгц урдаас нь харж тэмдэглэнэ.

II ХАРИЛЦЪЯ, ХАМТАРЪЯ



Манай гэрийнхэн
Миний гэр орон
Бид юу сурсан бэ?



ААВ, ЭЭЖИЙН МЭРГЭЖИЛ, АЖИЛ ХӨДӨЛМӨР



Би ургийн бичиг хөтлөх явцдаа аав, ээжийнхээ мэргэжил, ажил хөдөлмөрийн тухай судалж мэдсэн.

Мэргэжил, ажил хөдөлмөр хоёр ялгаатай юу?



Гэрийнхнийхээ мэргэжил, ажил хөдөлмөр, ажлын газрыг судалж мэдээлэл бэлтгэе.



Дасгал 1. Дотны 3 найзаасаа бэлтгэсэн асуултын дагуу мэдээлэл цуглуулж мэргэжил, ажил хөдөлмөрийн онцлогийн талаар ярилцаарай.

Асуух асуултаа бэлтгээрэй.	Хэнээс асууж ямар мэдээлэл цуглуулсан вэ?
Танай аав ямар мэргэжилтэй вэ? Ямар хөдөлмөр эрхэлдэг вэ? Ажлын газар нь хаана байрладаг вэ? ГЭХ МЭТ	

Дасгал 2. Бидний аав, ээж ажил хийж авсан мөнгөө хүнсний бүтээгдэхүүн болон хэрэгцээтэй зүйлд зарцуулдаг. Аав ээжийн мөнгө хязгаартай тул тэдний өгсөн мөнгийг зөв зарцуулахын тулд яах ёстой вэ?

А. Өөрийн хэрэгтэй зүйл, хүссэн зүйлээ 2 баганад ялган бичээрэй.

Хэрэгтэй зүйлс	Хүссэн зүйлс

Б. Аав, ээжийн өгсөн мөнгийг чи хэрхэн зарцуулах вэ? “Миний санхүү” дэвтэр хэрэглэж, мөнгөний тооцоог гаргаарай. Чиний хэрэгтэй болон хүссэн зүйлийг худалдан авахад хүрэлцэх үү?

Өдөр	Хэнээс авсан бэ?	Өгсөн мөнгө	Зарах мөнгө	Юунд зарцуулах вэ?
1/12	Ааваас	5000		
1/20	Ээжээс	1000		

В. Хэрэглээ, хадгаламж, тусламж гэсэн 3 дугтуй бэлтгэж аав, ээжийн өгсөн мөнгийг 10 хувааж, тавыг нь хэрэглээний дугтуйд, гурвыг нь хадгаламжийн дугтуйд, хоёрыг нь тусламжийн дугтуйд хийж хэвшээрэй. Тооцоог хийгээрэй.

Өдөр	Хэнээс авсан бэ?	Өгсөн мөнгө	Зарсан мөнгө	Тусламжид үлдээсэн мөнгө	Хадгаламжид үлдээсэн мөнгө
1/12	Ааваас	5000			

Бидний аав, ээж ажил хөдөлмөр эрхэлж цалин хөлс авдаг.

УДАМ ТӨРЛӨӨ МЭДЭЦГЭЭ



Ургийн бичиг хөтлөх ямар ач холбогдолтой вэ?

Ургийн бичиг хөтлөх зураглал ашиглан өөрийн 5 үеийг тэмдэглэе.




Дасгал 1. Ургийн бичиг хөтлөх мэдээллийг дараах дарааллаар бэлтгээрэй.

- Төрөл садан хүмүүсийн нэр, нас, хүйс, төрсөн газар
- Гэрийнхэн болон төрөл садан хүмүүсийн фото зураг
- Бичиг баримт цуглуулах (намтар, захиа, сонин хэвлэл)
- Дурсгалт зүйл цуглуулах (ном, зурсан зураг, эд юмс)
- Ахмад хүмүүстэй уулзаж ярилцаж тэмдэглэл хөтлөх


Дасгал 2. Асуултын дагуу ярилцаарай.

- Танай гэрийнхнээс хэн нь угийн бичиг хөтөлсөн бэ?
- Дараах дүрс тэмдэглэгээг уншаарай. Юуг тэмдэглэсэн байна вэ?
- Чи ургийн бичгээ хөтлөх мэдээллээ хэнд хандаж бэлтгэх вэ?

Дасгал 3. Дэвтэртээ таних тэмдгийг зураад гэрийнхэндээ тайлбарлаарай.




Дасгал 4. Ургийн бичгийн 3 үеэ хөтлөхдөө цуглуулсан мэдээллээ ашиглаарай. Найз нөхдөдөө танилцуулаарай.




Бидний өвөг дээдэс ургийн бичиг буюу гэр бүлийн түүхээ тэмдэглэж үр хүүхдэдээ өвлүүлж ирсэн уламжлалтай. Ургийн бичиг хөтлөх нь аав, ээжийн төрөл садан, үе удмаа мэдэх, тэднийг хүндэтгэх, эрүүл мэндийн дэглэмийг сахин хэвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

ХААНА ЮУ БАЙНА ВЭ?

Зурагт гэр доторх зүйлийг дүрслэн үзүүлжээ. Энэ хоёр зураг ямар ялгаатай байна вэ?



Зураг 1



Зураг 2

Дасгал 1. Дараах зургуудийг эгц дээрээс нь хараад зураарай. Яаж зурснаа найзууддаа тайлбарлаарай.



Ангид байгаа зүйлсийг эгц дээрээс харсан байдлаар зурж болох уу?

Болно. Харин юуг оруулж зурахаа ярилцах нь зүйтэй байх



Дасгал 2. Анги доторх зүйлсээс зурагт юуг оруулж дүрслэхээ ярилцаад нөхөж бичээрэй.

Ангийн өмнө байна. Ангийн зүүн талд байна.
Ангийн баруун талд байна. Ангийн хойд талд байна.
Ангийн төв хэсэгт байна.

Дасгал 3. Ангиа эгц дээрээс нь харсан байдлаар зурж дүрслээрэй. Хаана юуг ямар дүрсээр дүрсэлж зурах таних тэмдгийг эхлээд зураарай.


ГЭРЭЭС СУРГУУЛЬ ХҮРТЭЛ



Чи гэрээсээ сургууль хүртэл явах замаа заагаарай. Хоорондоо ярилцаарай.




Дасгал 1. Зургийг ажиглаарай. Болд, Мишээл, Бат 3 гэрээсээ сургууль хүртэл хаагуур явах талаар ярилцаарай.



Дасгал 2. Зураг дээр Болд, Мишээл, Бат нарын гэрээс сургууль хүрэх замыг зураарай.

Дасгал 3: Гэрээсээ сургууль хүртэл явах “аюулгүй” замыг сонгоорой.



Аливаа зүйлсийг дээрээс харсан байдлаар тоймлон зурж болдог. Үүнийг план зураг гэнэ.

БИД ЮУ СУРСАН БЭ?


1. Бат дэлгүүрээс үзэг авахдаа худалдагчийн өгсөн хариулт мөнгийг тоололгүй авч гэртээ харив. Гэтэл худалдагч түүнд 300 төгрөг илүү өгсөн байлаа.

А. Дараах бодомжуудаас алийг нь сонгох вэ? Сонгосон хувилбараа тайлбарлаж бичнэ үү?


1. Мөнгө илүү авснаа хэнд ч хэлэхгүй байсан нь дээр
2. Дэлгүүрт очоод худалдагчид хэлээд мөнгийг нь буцааж өгнө.
3. Худалдагчийн буруу тул буцааж өгөх шаардлагагүй.
4. Надад мөнгө хэрэгтэй байгаа тул дараа өөр юманд зарцуулна.

Б. Найз чинь “Мөнгө илүү авснаа хэнд ч хэлэхгүй байсан нь дээр” бодомжийг сонгосон бол чи юу гэж зөвлөх вэ?

2. Дараах загварыг ашиглан өөрийн гурван үеийнхээ нэрийг бичээрэй



3. Зургаан баг болоод ширээ тус бүрийн план зургийг зураарай. Дараа нь ширээ тус бүрийн план зургийг эвлүүлж тавиад хэрхэн дүрсэлсэн талаар хэлэлцүүлэг хийгээрэй.



III СУРГУУЛЬТАЙГАА ТАНИЛЦЪЯ



Сургуулийн гадаад орчин
Сургуулийн дотоод орчин
Бид юу сурсан бэ?



СУРГУУЛИЙНХАА ТҮҮХИЙГ СУДАЛЪЯ




Би сургуулиараа
бахархдаг.

Би сургуулийнхаа талаар
илүү ихийг мэдэхийг
хүсэж байна.



Сургуулийнхаа түүхийг хамтран судалцгаая.




Дасгал 1. Загварыг ашиглан сургуулийнхаа түүхийг судалсан мэдээллээ тэмдэглэж ярилцаарай.

Манай сургуулийн нэр	Манай сургуулийн анхны нэр
Анги танхимын тоо	Байгуулагдсан он Анги, танхимын тоо
Багш Ажилчид Сурагчид.....	Манай сургуулийн анхны багш..... Ажилчид..... Сурагчид
Захирал	Анхны захирал.....
Манай сургуулийн барилга.....	Манай сургуулийн анхны барилга.....

Дасгал 2. Чамд сургуулийнхаа юугаар бахархах сэтгэл төрдөг вэ? Яагаад вэ? Өөрийнхөө бахархдаг зүйлсийг зураг, бичгээр тэмдэглэж ярилцаарай.

Дасгал 3. Цуглуулсан мэдээллээ ашиглан сургуулийн түүхийн шугам байгуулж тайлбарлаарай.



Дасгал 4. “Сургуулийн түүх” бяцхан ном бүтээж ангийн номын сангаа баяжуулаарай.

СУРГУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Бид сургуулийнхаа орчны замын хөдөлгөөнийг ажиглаж тэмдэглэхийн учир юу вэ? Хамтран хэлэлцье.



Сургуулийн гадаад орчны замын хөдөлгөөнд ажиглалт хийсэн тэмдэглэлээ хамтран дүгнэе. Замын хөдөлгөөнд осол аюулгүй зорчих дүрмийг хэвшүүлье.




Дасгал 1. Бид сургуулийн гадаад орчинд юуг ажиглаж тэмдэглэх вэ?

1. Сургуулийн аль зүгт авто зам байна вэ?
2. Аль зам нь ойр, аль зам нь хол байрласан байна вэ?
3. Сургуулийн гадаа 5 минут анхааралтай зогсож машины хөдөлгөөнийг ажиглан, хичнээн машин өнгөрч байгааг тоолоорой.
4. Замын хөдөлгөөний ямар тэмдэглэгээ хаана байгааг ажиглаж тэмдэглээрэй.

Дасгал 2. Сургуулийн орчны замын хөдөлгөөнийг ажиглаж, тэмдэглэсэн тэмдэглэгээг хамтран дүгнээрэй.

- Сургууль орчны зүг чигийг тэмдэглэн зурна.
- Авто машины зам сургуулийн аль зүгт хэд байна вэ?

Баруун Зүүн Хойд Урд



- Аль зам нь хол, аль зам нь ойр байна вэ?
- 5 минутад өнгөрсөн машины тоо хэд байна вэ?
- Аль зүгт машины хөдөлгөөн их байна вэ?
- Хаана замын тэмдэглэгээ байхгүй байна вэ?
- Хэрвээ танай сургуулийн орчинд машины хөдөлгөөн бага буюу байхгүй бол гэрийнхээ ойр орчны авто машины хөдөлгөөнийг ажиглаж тэмдэглээрэй.



Замын хөдөлгөөнд оролцохдоо гэрлэн дохио, гарцын дүрмийг баримтална. Хэрвээ гэрлэн дохио, гарцын тэмдэг байхгүй бол машины хөдөлгөөнийг өнгөрөөж зорчино. Энэ нь бидний эрүүл мэнд, аюулгүй байдалд тустай гэдгийг санаж явъя.

НОГООН ГЭРЭЛ, ЦАГААН ШУГАМ



Зам гарч чадахгүй байгаа найздаа хэрхэн туслах вэ?




Мөн замын хөдөлгөөнд хэрхэн зөв, соёлтой оролцох талаар ярилцагаяа.



Дасгал 1. Хүүхдүүд та нар аль тэмдгийг нь мэддэг вэ? Найзууддаа тайлбарлан өгөөрэй.



Унадаг дугуйн
хөдөлгөөн хориотой



Орох
хориотой





Явган зорчигчийн
хөдөлгөөн хориотой




Хүүхэд

Дасгал 2. Сурагчид сургууль руугаа ганцаараа явах болжээ. Ээж нь тэд нарт юу захисан бэ? Зургийг харж тайлбар бичээрэй.



Дасгал 3. Хүүхдүүд ямар буруу үйлдлүүд хийж байгааг ярилцаарай. Найздаа хэрхэн зөвлөх вэ?



Дасгал 4. Сурагчид хэний гэрээс сургууль хүрэх замд илүү олон болгоомжлох зүйл байгааг олж тогтоох судалгаа хийжээ.

Цэлмүүний багийн хийсэн судалгааны дүн хүснэгтэд бичигдсэн байна.

1. Судалгааны дүнг эрэмбэлээд баганаан диаграммаар илэрхийлээрэй.
2. Хэнд ямар зөвлөгөө өгөх вэ? хамтран ярилцаарай

	Нэр	Болгоомжлох газрын тоо
1	Цэлмүүн	8
2	Ану	4
3	Тэнгис	6
4	Гэрэл	10
5	Билгүүн	5

Эрэмбэ
1. цөөн
2.
3.
4.
5. олон



Өөрийн багт байгаа сурагчдын судалгааны дүнг хүснэгтэд бичээрэй. Судалгааны дүнг баганаан диаграмм ашиглан илэрхийлээрэй.



Замын хөдөлгөөнд оролцохдоо гэрлэн дохиог сайтар анхаарах хэрэгтэй. Гэрлэн дохиог замын уулзвар, гарц, хамгийн аюултай хэсэгт байрлуулсан байдаг. Зорчих хэсгээр хөндлөн гарахдаа зөвхөн ногоон гэрэл ассан үед зорчино гэдгээ бүү мартаарай. Шар гэрэл анхааруулж, улаан гэрэл хөдөлгөөнийг хорьдог гэдгийг сайн санаарай.



ДУУ ЧИМЭЭ




Яагаад дуу өөр өөр
сонсогддог вэ?

Туршилт хийж
үзэцгээе.





Дасгал 1. Хамтран туршилт хийж дүгнэлтээ ярилцаарай.

- Нарийхан төмөр шугам аваад нэг үзүүрийг ширээн дээр тавьж сайн дараарай.
- Харин нөгөө үзүүрийг ширээнээс гадагш цухуйлган байрлуулна.
- Шугамын үзүүр дээр сайн дарж байгаад тавиарай. Юу ажиглагдсан бэ?
- Шугамаа богино болгоод туршилтыг давтан хийгээрэй. Ялгаа байна уу?
- Шугам богино болох бүр шугамын гаргаж байгаа дуу өөрчлөгдөж байна уу?.



Дасгал 2. Ямар амьтан бүдүүн дуу, ямар амьтан нарийн дуу гаргадаг вэ?



Дасгал 3. Чиний хоолойноос гарч байгаа дуу ямар вэ? Нарийн уу? Бүдүүн үү? Өөрийнхөө дууг аав ба бусад хүмүүсийн дуутай харьцуулаарай.

Дасгал 4. Хоосон тасалгаанд дуу чимээ их байдаг. Харин эд хогшил тавьж, хивс дэвсэж, хөшиг өлгөсөн өрөөнд дуу чимээ багасдагийн учрыг судлаарай.



Чичирч байгаа зүйлээс дуу гардаг. Гарч байгаа дуу бүдүүн нарийн янз бүр сонсогддог.

УРГАМЛЫН ҮРИЙГ ЦУГЛУУЛЪЯ



Ургамал хаанаас яаж ургадаг вэ?

Ургамал үрээр ургадаг гэж аав надад тайлбарласан.



Тийм шүү, ихэнх ургамал үрээс соёолж ургана.

Дасгал 1. Ургамлын үр цуглуулаарай. Том, жижиг үрийг шугам хэрэглэн хэмжиж, ялгаарай.





Туршилт 1.

Нэг наст цэцэгт ургамлын үрийг тарьж ургуулъя.

1. Бүтэн, гэмтээгүй үрийг сонгоно.
2. Үр суулгах хөрсийг бэлтгэнэ.



3. Маш жижиг үрийг хөрсөн дээр цацаж элсээр булаарай.
4. Харин жижиг үрийг өнгөц, том үрийг гүн суулгана. Яагаад гэдгийг тайлбарлаарай.



Зарим ургамал үр жимсээ өгөөд дараа жил дахин ургадаггүй. Ийм ургамлыг нэг наст ургамал гэнэ. Нэг наст ургамлыг дахин ургуулахын тулд үрийг нь түүж авах хэрэгтэй. Ургамлын үрийг намар үр боловсорсны дараа хуурай цаасан уутанд түүж цуглуулаад, сэрүүн газар хатааж, чийгээ бага алдах таглаатай саванд хадгална.

УРГАМАЛ УРГАХАД ГЭРЭЛ, УС ХЭРЭГТЭЙ ЮУ?



Ургамал амьд бие учраас хооллоно бас өсөж үржинэ.

Багш аа, ургамал яаж хооллодог юм бэ? Бидэнд тайлбарлаж өгөөч.



Хэрэглэгдэх зүйлс:

- 3 ширхэг шилэн аяга
- Цэвэр ус ба будагч бодис
- Ургамлын тос
- Цаас, цавуу, хайч
- 2 ширхэг тайралт хийж үндэслүүлсэн тасалгааны ургамал




Дасгал 1. Зургийг ажиглаад гэрэл дутагдахад ургамалд ямар өөрчлөлт гарч болох талаар ярилцаарай.

Хангалттай гэрэлтэй үед	Гэрэл дутагдсан үед
	


Туршилт 1.

- 2 шилэн аяганд ижил хэмжээтэй ус хийж тайралт хийсэн тасалгааны ургамлыг дүрнэ.
- Бага зэргийн нимгэн давхарга үүсгэж ургамлын тос нэмээд цонхон дээр тавиарай.
- 3,5,7 хоногийн дараа ямар өөрчлөлт орсон байх талаар таамаглал дэвшүүлнэ.
- 3,5,7 хоногийн дараа гарсан үр дүнг ажиглаад дэвшүүлсэн таамаглалаа батлаарай. Яагаад гэдгийг бусдадаа тайлбарлаарай.



Туршилт 2.

- Харандаанд цаас хуйлж наагаад модны иш хийгээрэй. Дараа нь навчийг нааж, доороос нь 2 см орчим хайчилж үндэс гаргаарай.
- Шилэн аяганд будагтай ус (бэх) хийж, цаасаар урласан модны зөвхөн үндэсний хэсгийг дүрнэ.
- 3, 5, 7 минутын дараа ямар өөрчлөлт орсон байх талаар таамаглал дэвшүүлнэ.
- 3, 5, 7 минутын дараа гарсан өөрчлөлтийг ажиглаад дэвшүүлсэн таамаглалаа батлаарай. Яагаад гэдгийг дараах зураг ашиглан бусдадаа тайлбарлаарай.



Дасгал 2. Ургамлыг услахад учиртай. Дараах тайлбарыг уншаад яагаад гэдгийг ярилцаарай. Тасалгааны ургамлыг услахад юуг анхаарах вэ? Санамж бичиж ангийнхаа тасалгааны ургамлын саван дээр наагаарай.

Улирлын онцлог	Хэрхэн яаж услах вэ?
Өвлийн улирал	<ul style="list-style-type: none"> • Савтай ургамлын хөрс хатаж байгаа эсэхийг анхааралтай ажиглаж усалгааг багасгана. • Агаарыг чийгшүүлэх усалгааг тохируулж орчныг шүршиж усална. • Өглөө услах нь тохиромжтой.
Зуны улирал	<ul style="list-style-type: none"> • Усалгааг нэмэгдүүлнэ. • Агаарыг чийгшүүлэх усалгааг эрчимжүүлж навч ба орчныг шүршиж усална. • Орой бүр идэвхтэй услах нь тохиромжтой.



Ургамал үндсээрээ ус, эрдэс давсыг сорон авч ишээр дамжуулан навчинд хүргэнэ. Хүн, амьтан хоолоо идэхийн тулд байнга явах шаардлагатай байдаг бол ургамал ургасан газраасаа хоол тэжээлээ олж авдаг.

УРГАМЛЫН ҮНДЭС ӨСДӨГ ҮҮ?



Ургамал амьд биет
учраас өсөж хөгждөг.

Хөрсөнд байгаа үндэс яаж
өсдөг вэ?



Тасалгааны ургамлын зөөлөн ногоон ишээс үндэс хэрхэн ургаж бий болохыг туршилт хийж ажиглацгаая.

Хэрэглэгдэх зүйлс:

- Богино хугацаанд үндэслэдэг тасалгааны ургамал (шимтэглэй буюу хайтан мөн эрээн сүлжгэнэ)
- Цаасны хутга
- Шилэн сав



Туршилт 1.

1. Шилэн савандаа усаа хийж бэлтгэнэ.
2. Сонгосон тасалгааны ургамлаас үндэслүүлэх ишийг цаасны хутгаар налуу чиглэлтэйгээр зүсэж авна (4-5 үе оролцуулж ишийг зүснэ).
3. Шилэн савтай усанд зүсэж авсан ургамлын ишээ дүрж байрлуулна.
4. 1-2 хүртэл ургамлын (№ 1 шимтэглэй, № 2 эрээн сүлжгэнэ гэх мэт) ишийн шилэн савтай суулгац бэлтгэнэ.
5. Шилэн савтай ишийн хэсгийг гэрэл туссан цонхны тавцан дээр байрлуулна.
6. Ишийн суулгац хийсэн шилэн саваа 1-2 хүртэл дугаарлаж саван дээрээ наана.
7. Суулгац тус бүрийн үндсэлсэн хугацаа болон уртыг хэмжиж дэвтэртээ бичээрэй.



Дасгал 1. Дараах асуултад хариулж дүгнэлт гаргаарай.

1. Туршилтад сонгож авсан 1 ба 2 дугаар суулгацын үндэс хэдний өдөр анх цухуйж эхэлсэн вэ?
2. Үндэсний болон ишийн урт өөрчлөгдөж байна уу?
3. Үндэс, иш өсөж ургахад ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?

НАВЧИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ



Ургамлын навч янз бүр байх юм. Яагаад өөр өөр байдаг юм бэ?

Ургамлын үндэс ургаж, өсдөгийн адил навч ч гэсэн ургаж, өсдөг үү?



Тасалгааны ургамлын навчийн ялгаатай байдал, өсөж томорч байгааг туршилт хийж ажиглацгаая.

Хэрэглэгдэх зүйлс:

- Өмнөх хичээл дээр үндэслүүлсэн тасалгааны ургамлыг (шимтэглэй, эрээн сүлжгэнэ)-ыг ашиглана.
- Ангидаа ургуулсан тасалгааны ургамлаас олон салаа мөчиртэй ургамлыг сонгоно.
- Өнгийн нарийхан наалттай цаас, шугам бэлтгэнэ.




Туршилт 1.

Өмнөх хичээл дээр үндэслүүлсэн тасалгааны шимтэглэй, эрээн сүлжгэний навчийн судлыг өсгөгч шил ашиглан хараад дуурайн зурж дүрслээрэй.



Дасгал 1. Навчийн судлыг мэдсэнээр тэр ургамлын үндэс ямар болохыг хялбархан мэдэж болно. Өөрөөр хэлбэл заавал хөрсийг ухаж үндсийг харах шаардлагагүй юм. Өмнөх хичээлийн ажиглалт дээр тулгуурлан зөв бол \checkmark , буруу бол X тэмдэг тавиараарай.



Туршилт 2.

1. Таван сурагч дундаа навчийн өсөлтийг ажиглах нэг тасалгааны ургамлыг сонгоно (ишин дээр 10-15 хүртэлх тооны навчтай ургамал сонгоорой).
2. Сонгосон ургамлын навчийн тоог гаргана.
3. Өнгийн нарийхан наалттай цаасан дээрээ навчийн тоог дугаарлаж бичээд наана.
4. Дугаарласан навчийн уртыг шугамаар хэмжинэ.
5. Баг тус бүрийн 5 сурагч өөрсдийнхөө сонгож авсан навчинд хэмжилт хийсэн тэмдэглэгээг дэвтэртээ бичнэ.
6. Сонгосон ургамлын гурвыг нь гэрэлтэй цонхон дээр, хоёрыг нь харанхуй шүүгээнд байрлуулж хөрсийг хатаахгүйгээр усална.
7. 7-14 хоногийн дараа дахин хэмжиж, тэмдэглэл хөтлөөд харьцуулаарай.

Дасгал 2. Дараах асуултад хариулж дүгнэлт хийгээрэй.

1. Сурагч тус бүрийн сонгож авсан ургамлын навчийн тоо, хэмжээ өөрчлөгдсөн байна уу? Хэрвээ сонгож авсан ургамлын навчийн тоо, хэмжээ өөрчлөгдсөн бол ямар хүчин зүйлтэй холбоотой болохыг тайлбарлаарай.




Ургамал амьд бие учир түүний бүтцийн хэсгүүд болох үндэс, иш, навч нь өсөж ургадаг.

БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Сургуулийнхаа түүхийг бичээрэй.

Манай сургууль..... онд байгуулагдсан. Одоо нийт анги танхимтай. Гуравдугаар ангийн бүлэгтэй. Манай сургуулийн захирлыг..... гэдэг.

2. Аль нь зөв бэ? Яагаад? Тайлбарлаарай.



3. Манай сургуулийн ойролцоо машин засварын газар байдаг. Энэ нь бидний амьдралд хэрхэн нөлөөлөх вэ? Өөрийн бодлоо бичээд найзуудтайгаа ярилцаарай.


4. Өөрийн сонгож ургуулсан үрийн хэмжээ болон хөрсөнд суулгасан гүний хэмжээг хүснэгтэд тэмдэглээрэй.

Үрийн хэмжээ (мм)	Хөрсөнд суулгасан гүн (мм)

5. Сонгож ургуулсан ургамлынхаа үндэс, ишийн уртыг 5 өдөр хэмжиж, тус бүрийг баганан диаграммаар илэрхийлээрэй.


Өдөр	1	2	3	4	5
Үндэсний урт (мм)					

Үндэсний урт (мм)



Ишийн
урт (мм)

Өдөр	1	2	3	4	5
Ишийн урт (мм)					




6. Гэрэлтэй ба харанхуй газар 7 хоног байрлуулж, усалсан ургамлын навчинд ямар өөрчлөлт гарсан байна вэ? Навчийн урт, өнгөний өөрчлөлтийг ажиглаарай.



IV ОРЧНОО АЖИГЛАЖ, СУДАЛЪЯ



Орон нутаг ба хүмүүс
Орон нутаг ба байгаль
Бид юу сурсан бэ?



БИД БҮГДЭД ХАМААТАЙ





Дасгал 1. Зургийг ажиглаж гүйцэтгэнэ үү?

- А. Зурагт хэн, хаана, юу хийж байна вэ?
- Б. Зурагт байгаа газруудыг би болон гэр бүлийнхэн, бид болон бүх хүмүүсийн хэрэглэдэг зүйл гэдгээр нь ялган ✓ тэмдгээр тэмдэглээрэй.

Газрууд	Би болон манай гэрийнхэн хэрэглэдэг	Бид болон бүх хүмүүс хэрэглэдэг
Миний тоглоом	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Сургуулийн тоглоомын талбай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Миний арчилдаг ургамал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Малын бэлчээр	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Манай хашаа	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Манай гудамж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Миний цүнх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Автобусны буудал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

- В. Бидэнд болон бүх хүмүүст хамаатай гэж тэмдэглэсэн газруудын онцлог юу вэ? Яагаад чи энэ газрыг бидэнд буюу бүх хүмүүст хамаатай гэж тэмдэглэсэн бэ?

Дасгал 2. Бидэнд буюу бүх хүмүүст хамаатай газруудад явахад анхаарах зүйлс юу вэ? Зурагт үзүүлсэн үйлийг хийж болохгүй талаар хүүхдүүдэд анхааруулга бичээрэй.



Анхаар
Зам хөндлөн гарахдаа

Анхаар
.....

Анхаар
.....

БИД БА ДҮРЭМ



Дүрэм гэж юу вэ?

Хаана ямар дүрэм баримтлах вэ?



Зургийг хараад ярилцагсаа.



Тоглоом тоглох дүрэм:

.....




Сургуулийн орчинд баримтлах дүрэм:

.....

Дасгал 1. Бидэнд буюу бүх хүмүүст хамаатай газруудад ямар дүрэм баримтлах ёстойг зургаас харж бичээрэй.

- А. Гудамж талбайд
- В. Нийтийн бие засах газарт

- Б. Тоглоомын талбайд
- Г. Ногоон байгууламжид



Дүрмийг баримтлах нь бусдыг хүндэтгэх, орчноо цэвэр цэмцгэр байлгахад тустай.

ХААНА, ЮУГ МӨРДӨХ ВЭ?



Нийтийн бие засах газар, тээврийн хэрэгсэл, цэцэрлэгт хүрээлэнд юуг анхаарах вэ?

Нийтээр дагаж мөрдөх дүрмийг баримтална.



Хаана ямар дүрэм баримтлах вэ? Ярилцацгаая.

Бие засах газар

Би өөрөө

Миний найз

Бусад хүмүүс

Нийтийн тээврийн хэрэгсэлд

Суухдаа:

- Үйлчилгээнийхээ төлбөрийг төлөх

.....

Орсон хойноо:

- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд суудал тавьж өгөх

.....

Буухдаа ба буусны дараа:

- Машины хөдөлгөөн харж, гарцаар гарах

.....



Дасгал 1. Сургуулийнхаа бие засах газар баримтлах дүрмийг бичиж, найзууддаа танилцуулаарай.



Дасгал 2. Малчид хаваржаа болон зусландаа хэрэглэх нүүдлийн энгийн бие засах газрыг яаж хийх зөвлөмжийг уншаад 4 давуу талыг олж ярилцаарай.

Зөвлөмж

25 см орчим өргөнтэй нүхийг нутаглах хугацаанаас хамаарч гүнийг нь тохируулан ухаад, гарсан шороог ойролцоо овоолно.

- Нүхний гадуур 4 шон хатгаж гарын доорх материалаар хаалт хийнэ.
- Бие засах газрын хажууд хүрз, хутгуур заавал тавина.
- Хүндээр бие зассаны дараа шорооноос хүрзээр авч ялгадсыг бүрэн далдлана.
- Хэрэглэсэн цаас, даавуу зэргийг нүхэнд хийгээд шороогоор хучсан байхад хурдан задарч цэвэрших тул байгальд сөрөг нөлөөгүй.
- Нүүхдээ ухсан нүх дүүрээгүй байвал үлдсэн шороогоор нь дүүргэж булаад тэгшилнэ.

Дасгал 3. Дараах мэдээллийг хамтран ярилцаад санал солилцоорой.

№	Нийтийн тээврээр үйлчлүүлэхэд гарч буй сөрөг үзэгдлүүд	Сөрөг үзэгдлийг арилгахад юу хийх вэ?	Чи яаж оролцох вэ?
1.	Тээврийн хэрэгслийн цонхоор хог хаягдлаа хаях	Бусдад тайлбарлана.	Би өөрөөсөө эхэлж хэрэгжүүлнэ.
2.			
3.			

Дасгал 4. Цэцэрлэгт хүрээлэнгийн эд зүйлсийг хэн хамгаалдаг вэ? Бодоорой.

Жишээ нь:

- Зам гүүр
- Ногоон байгууламж
- Барилга байгууламж
- Гэрэлтүүлэг
- Амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх саравч, сандал, тоглоом
- Хөшөө дурсгал

Танай орон нутагт хаана, ямар цэцэрлэгт хүрээлэн байдаг вэ?

Тэнд ямар ямар эд зүйлс байдаг вэ?

Дасгал 5. Нийтийн эзэмшлийн газрын эд зүйлсийг ашиглахын тулд хамгаалах хэрэгтэй. Энэ талаар орон нутгийнхаа иргэдэд зориулсан санамж бичигцгээе.



Дасгал 6. “Миний мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн” сэдэвт зураг зураарай.

Дасгал 7. “Мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн”-д ямар дүрэм мөрдөх вэ? “Алтан дүрэм” боловсруулаад дараа нь анги хамт олондоо хэлэлцүүлээрэй. Яагаад “Алтан дүрэм” гэж нэрлэсний учрыг тайлбарлаарай.

МАНАЙ НУТАГТ УРГАДАГ УРГАМАЛ



Ойд ургамлууд өндөр, нам янз бүр ургах юм бүгдийг нь мод гэж нэрлэх үү?

Ялгаатай байдлаар нь ангилдаг байх гэж бодож байна.



Аль нь модлог, сөөг, өвслөг ургамал болохыг ялган таныцгаая.



1

Модлог ургамлын гол иш нь..... онцлогтой.



2

Сөөг ургамлын иш нь..... онцлогтой.



3

Өвслөг ургамлын иш нь..... онцлогтой.



Сургуулийн гадаа талбайд гарч мод, сөөгийг тоолоорой. Түүний хэд нь ургаж байна вэ? Ургахгүй байгаа мод, сөөгний тоог гаргаж ангидаа орж ирээд яагаад гэж асуудал дэвшүүлэн ярилцаарай.



Дасгал 1. Шилмүүст мод нь навч болох шилмүүсний тоо, шилмүүсний урт богиноор ялгаатай.

Нэг нахианаас гарах шилмүүсний тоог тоолох ба уртыг нь хэмжиж тэмдэглээрэй.

				
Нарс	Хуш	Гацуур	Шинэс	Арц
				
Шилмүүсний тоо... Шилмүүсний урт...	Шилмүүсний тоо... Шилмүүсний урт...	Шилмүүсний тоо... Шилмүүсний урт...	Шилмүүсний тоо... Шилмүүсний урт...	Шилмүүсний тоо... Шилмүүсний урт...

Дасгал 2. Навчит мод. Танай орон нутагт ургадаг бол ✓ тэмдэглэгээ тавиарай.

Улиас	Хайлаас	Чацаргана	Тоорой
			
Хот тохижилтод тарьж ургуулахад тохиромжтой модлог ургамал.	Хайлаасны үр 5-6-р сард боловсордог тул энэ үед үрийг түүж цуглуулж болно.	Тарьснаас хойш 2-3 жилийн дараа үр жимсээ өгч эхэлдэг.	Говь нутгийн хамгийн том модлог ургамал.

Дасгал 3. Сөөг ургамал. Танай орон нутагт ургадаг бол ✓ тэмдэглэгээ тавиарай.

Бургас	Нохойн хошуу	Шар хуайс	Үхрийн нүд
Элс, шаварлаг хөрсөнд ургадаг сөөг ургамал.	Иш, навчийн бариул хурц өргөстэй. 5 дэлбээ бүхий ягаан цэцэгтэй ургамал.	Хотын ногоон байгууламжид нэг эгнээгээр суулгадаг гоёл чимэглэлийн сөөг.	Сайн арчилбал үхрийн нүдний 1 бутнаас 4-5 кг жимс хураан авах боломжтой.

Дасгал 4. Өвслөг ургамал. Танай орон нутагт ургадаг бол ✓ тэмдэглэгээ тавиарай.

Яргуй	Төмсний улаан	Үлдөвс	Цагаантүрүү




Ургамлын онцлог	Ямар ургамал вэ?	Орон нутагт ургадаг ургамлын жишээ бичээрэй.
Бүдүүн иштэй, олон салаалсан мөчиртэй. Өндөр ургадаг.		
Олон салаалсан нарийхан иштэй. Урт үндэстэй.		
Шүүслэг, зөөлөн, богинохон иштэй.		

АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧНЫ ЯЛГАА



Дасгал 1. Дээрх амьтад хаана амьдардаг вэ? Зурагт харгалзуулан тохирох амьтны нэрийг бичээрэй.



Дасгал 2. Дараах загварын дагуу дээрх амьтад юугаар хооллодог, амьдрах орчиндоо хэрхэн зохилдсон талаар мэдээлэл цуглуулж найзууддаа танилцуулаарай.



Хүрэн баавгай

Ойд амьдардаг. Хавар модны нахиа, үр, ургамлын үндэс, хуучин самар, шоргоолж зэргээр харин зун ногоон ургамал, самар, жимс жимсгэнэ, шавж, загас, заримдаа сэг зэмээр хооллоно. Өвөл идэш тэжээл нь хомсддог тул ихэвчлэн 10-5 дугаар саруудад ичдэг. Үр төлийг нь бамбарууш гэнэ.



Хөрс, ус, агаар бол манай дэлхий дээрх амьд биеийн амьдрах орчин болно. Амьд биеийн амьдралын үйл ажиллагаа амьдрах орчиндоо зохилдсон байдаг.

АМЬТАД ЯМАР АЧ ТУСТАЙ ВЭ?



Бид мал амьтнаас авдаг хэрэгцээтэй зүйлийг юу гэж хэлэх вэ? Чи мэдэх үү?

Хүмүүсийн малаас авч хэрэглэдэг зүйлийг малын ашиг шим гэнэ. Иймээс мал амьтдыг өсгөн үржүүлж, хайрлан хамгаалах хэрэгтэй.




Өөрт хэрэгтэй, худалдан авахыг хүсэж байгаа зүйлсийн жагсаалтыг гаргаарай. Тэдгээр зүйлс хэрхэн яаж буй болж, хувиран өөрчлөгдсөн (гарал үүсэл)-ийг судалцгаая.



Дасгал 1. Өөрт хэрэгтэй, ойрын хугацаанд худалдан авахыг хүсэж байгаа зүйлсийг зураад, хоол хүнс, хувцас, бусад зүйлст ангилан бичээрэй.

Надад хэрэгтэй байгаа зүйлс	Ангилал		
	Хоол хүнс	Хувцас	Бусад

Дасгал 2. Хэрэгтэй гэж сонгосон хоол хүнс, хувцас, бусад зүйлсийг дараах бүдүүвчийн дагуу гарал үүслээр нь ангилаарай.



Дасгал 3. “Д” ноосон цамцаа 2 жил гамтай өмссөн. Харин “С” сүүлийн 3 жил тутам цэвэрхэн харагдана гэж үзээд жил бүр шинэ ноосон цамц худалдан авч өмссөн. Дээрх тохиолдолыг харьцуулж давуу, сул талыг тэмдэглээд, бусад сурагчдын саналыг сонсоорой

Дасгал 4. Бид хүссэн бүхнээ худалдан авах нь зөв үү? Мал, амьтнаас авах ашиг шимтэй холбон тайлбарлаарай.

Дасгал 5. Хэрэгцээнээсээ илүү гарсан хувцас, эд зүйлсээ яах вэ? Сонгох хувилбараас хамгийн чухал гэдгээс нь эхлэн дугаарлаад тайлбарлаарай.

Бусдад бэлэглэнэ Худалдана Дүүдээ өгнө Гамтай хэрэглэнэ Хүссэн зүйлээ авч хуучнаа устгах нь зөв.

Амьтад ямар ач тустай байна вэ? “Амьтдыг хамгаалахад миний оруулах хувь нэмэр” жижиг ном бүтээж бусадтай ярилцаарай.

БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Ямар учраас нийтийн эзэмшлийн газар дүрэм мөрдөх хэрэгтэй вэ? Хамааралгүй хариултыг нь сонгоорой.

- эзэн харьяалал нь тодорхойгүй тул
- хэн нэгний хэрэглээний газар тул
- хил хязгаар тогтоох боломжгүй тул
- бусдад хэрэглэх, ашиглах боломж бүрдүүлэхийн тул
- ашиглах, хамгаалах эзэн тодорхойгүй тул

2. Дүрэм биелүүлэхгүй хэн нэгэнд яаж туслах вэ? Дараах үйлдлийг үйл үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------|-----------------|
| 1. Санаж бичих | а. Тайлбарлана. |
| 2. Өөрөөсөө эхлэх | б. Хэлэлцүүлнэ. |
| 3. Хамтарч ажиллах | в. Зөвлөнө. |
| 4. Харилцан ярилцах | г. Үлгэрлэнэ. |
| 5. Зөвлөмж бичих | д. Сануулна. |

3. Амьтдыг амьдрах орчны ялгаатай байдлаар нь ангилан бичээрэй (Туулай, үнэг, чоно, тарвага, зурам, шилүүс, хэрэм, буга, гүрвэл, хавтгай, бөхөн, хар сүүлт, аргал, янгир, хулан, тахь, хулгана, зурам, ангир, галуу, хун, тогоруу).

Ойн амьтад	Хээр талын амьтад	Говь цөлийн амьтад	Усны амьтад

4. Ургамлын нэрийг зөв харгалзуулан холбоорой. Яаж таньсан бэ? Тайлбарлаарай.

- | | |
|-----------------|-----------|
| 1. Нарс | А. Өвслөг |
| 2. Нохойн хошуу | Б. Сөөг |
| 3. Яргуй | В. Модлог |

5. Ямар ургамлын навч болохыг нэрлээрэй (улиас, монос, шар хуайс).



А



Б




В

6. Малын ашиг шим гэж юуг хэлэх вэ? Тайлбарлаарай.

V ЭХ ОРОН БА ДЭЛХИЙГЭЭ СУДАЛЪЯ



Эх орон
Эх дэлхий
Бид юу сурсан бэ?



МАНАЙ ОРОН ХААНА ОРШДОГ ВЭ?




Болдын ах нь Орос улсад сурдаг. Хулангийн аав Хятад улс руу хуралд оролцохоор явсан. Харин би Монголд амьдардаг. Энэ улсууд хаана байдгийг хэрхэн мэдэж болох вэ?

Үүнийг мэдэхийн тулд бидэнд глобус тусална.



Дэлхийн гадарга дээр хаана ямар зүйлс байдгийг глобус дээр дүрсэлж үзүүлдэг. Жишээ нь: Дэлхийн улс орнуудыг глобус дээр өөр өөр өнгөөр ялган тэмдэглэнэ. Глобусыг ажиглаарай.



Дасгал 1. Глобус ашиглан заагаарай.

- Монгол улс хаана оршиж байна вэ? Манай орон ямар өнгөөр тэмдэглэгдсэн байна вэ? Нэрлээрэй.
- Болдын ах сурдаг Орос улс хаана оршиж байна вэ? Глобус дээр олоорой. Орос улсыг ямар өнгөөр тэмдэглэсэн байна вэ?
- Орос улс манай орноос аль зүгт оршиж байна вэ? Зүгийг нэрлэж бичээрэй.
- Хулангийн аав ямар улс руу явсан бэ? Зурагт заагаарай. Хятад улс манай орноос аль зүгт оршиж байна вэ? Зүгийг нэрлэж бичээрэй.



Глобус бол дэлхийг багасган үзүүлсэн загвар юм.

ЭХ ОРНЫ ГАЗРЫН ЗУРАГ



Д. Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг уншицгаая.



*Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан нуруунууд
Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон*




Энэ шүлэгт юуны тухай гарч байна вэ? Ярилцаарай.

Дээрх шүлэгт гарсан уул нурууд хаана байдаг вэ? Түүнийг мэдэхэд монгол орны газрын зураг бидэнд тусална.



Дасгал 1. Монгол орны газрын зургийг ажиглаарай. Манай улсын нийслэл Улаанбаатар хот хаана байна вэ? Олоорой. Танай аймаг, сум хаана оршдог вэ? Заагаарай.


Дасгал 2. Монгол орны баруун ба хойд хэсгээр уулархаг, Алтай, Хангай, Хөвсгөлийн уулс оршино. Өндөр уул нуруудыг газрын зураг дээр улаан хүрэн өнгөөр дүрсэлдэг. Хэнтийн нуруу хаана оршиж байгааг Монгол орны газрын зураг дээр олоорой. Хангай ба Хэнтийн уулсын өндрийг харьцуулаарай. Аль нь өндөр вэ? Яагаад вэ? Хариултаа тайлбарлаарай.



Алтайн нуруу

Хангайн нуруу

Хэнтийн нуруу



Хөвсгөл




Буйр



Увс



Онон



Сэлэнгэ



Хэрлэн



Орхон



Туул

Дасгал 3. Тал газрыг зураг дээр цайвар өнгөөр тэмдэглэнэ. Манай орны аль хэсгээр талархаг байна вэ? Зургаас харж заагаарай. Танай нутаг уулархаг уу? Талархаг уу? Ярилцаарай.

Дасгал 4. Нам уулсыг арай цайвар хүрэн өнгөөр дүрсэлнэ. Танай нутагт хаана ямар уулс болон тал байдаг вэ? Дэвтэртээ нэрийг нь жагсаан бичээрэй.

“Миний нутаг” шүлгийг үргэлжлүүлэн уншаарай.



*Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд
Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд
Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон*

Дасгал 5. Шүлэгт дүрсэлсэн гол ба нуурууд хаана оршдог вэ?

Монгол орны газрын зургийг дахин ажиглъя. Гол мөрөн ба нуурыг газрын зурагт цэнхэр өнгөөр дүрсэлдэг. Манай оронд том нуур, гол мөрөн олон. Шүлэгт гарсан нуур ба голууд манай орны аль хэсэгт оршиж байна вэ? Зургийг ажиглан дараах хүснэгтийг гүйцээж бөглөөрэй.

Нэр	Нуур ба голын аль нь болох	Байрлал
Хөвсгөл	Нуур	Хойд хэсэгт
Увс		
Сэлэнгэ		
Ховд		
Буйр нуур	Нуур	Зүүн хэсэгт
Орхон		
Туул	Гол	Төв хэсэгт

Зарим нуур давстай байдаг бол зарим нуур цэнгэг устай. Давстай нуурыг газрын зурагт ягаан өнгөөр ялган тэмдэглэдэг. Давс ихтэй зарим нуураас давсыг нь шүүж хүнсэнд хэрэглэдэг. Жишээ нь: Сангийн далай нуураас давс олборлодог.

Дасгал 6. Хөвсгөл, Увс, Буйр нуур ямар аймгийн нутагт оршдгийг газрын зурагт заагаарай.

- Сэлэнгэ мөрөн ямар ямар аймгийн нутгаар дамжин урсдаг вэ?
- Туул гол ямар уулнаас эх авч хаана цутгадаг вэ?
- Танай орон нутагт ямар гол мөрөн нуур байдаг вэ? Нэрлээрэй
- Гол мөрөн нуурын ач холбогдлын тухай зохион бичлэг хийгээрэй
- Гол усаа хамгаалдаг монгол уламжлалын тухай мэдээллийг ахмад хүмүүсээс асуун цуглуулж бичээрэй.

Дасгал 7. Энэ улс манай орноос аль зүгт оршиж байна вэ?

- Манай улсын өмнө талд ямар улс байна вэ?
- Ази тивийн газрын зургийг ажиглаарай. Солонгос улс манай улсаас аль зүгт оршдог вэ?
- Казакстан улс Монгол улсаас аль зүгт байна вэ?



Дэлхийн гадаргыг хавтгай цаасан дээр буулгаж дүрсэлсэн зургийг газрын зураг гэнэ.

БУСАД ОРНУУДЫН ТУХАЙ СУДАЛЦГААЯ



Япон, Хятад хоёрын аль нь манай оронд ойр оршиж байна вэ?

Дэлхийн газрын зургаас харж мэдэж болно.



Дэлхийн газрын зураг глобусаас ямар ялгаатай вэ? Газрын зургийг ажиглаарай. Газрын зураг дээр улс орнуудыг өөр өнгөөр ялган үзүүлжээ.



Дасгал 1. Газрын зураг болон зүг чигийг ажиглаарай. Асуултад хариулаарай.

- Монгол улсыг ямар өнгөөр тэмдэглэсэн байна вэ?
- Монголоос зүүн тийш явбал ямар ямар улсад очиж болох вэ? 1-2 улсыг олж нэрлээрэй.
- Монголоос баруун тийш явбал ямар ямар улсад очиж болох вэ? 2-3 улсыг олж нэрлээрэй.
- Та нарын нэрлэсэн улсуудаас аль нь манай орноос хамгийн хол байна вэ?
- Англи, Франц, Америк зэрэг улс манайхаас баруун зүгт оршино. Эдгээр улсуудыг газрын зураг дээр олж заагаарай.
- Чи ямар улс руу аялахыг хүсдэг вэ? Газрын зураг дээр олоорой.

Дасгал 2. Ази тивийн газрын зургийг ажиглаарай. Өгүүлбэрийг нөхөөрэй.

Манай улс тивд байдаг.

Япон улс Монголоос зүгт оршдог.

Солонгос улс Монголоос зүгт оршдог.

Казахстан улс манай улсын талд байдаг.

Хятад улсын баруун өмнө талд улс байна.

Солонгос улсын зүүн талд улс оршдог.

ДЭЛХИЙН ХҮҮХДҮҮД



“Бидний найзууд” зургийг ажиглаарай. Ямар ялгаа байна вэ? Ярилцаарай.



Дасгал 1.

1. Эмми хаанаас ирсэн вэ?
2. София аль орных вэ?
3. Жамбо дэлхийн аль хэсэгт амьдардаг вэ?
4. Туяа аль улсын иргэн бэ?
5. Анита Энэтхэгээс иржээ. Энэтхэг хаана оршдог вэ?
6. Лук Австралид амьдардаг. Лук хэр зэрэг холоос ирсэн вэ?

Дасгал 2. Найзууд маань хаана амьдардаг вэ? Дэлхийн газрын зураг дээр заагаарай. Дэлхийн газрын зургийг ажиглаарай. Энд тив тус бүрийг өөр өөр өнгөөр ялган үзүүлжээ. Өнгийг нь ажиглаад тивийн нэрийг хүснэгтэд бичээрэй.

Дүрсэлсэн өнгө	Тивийн нэр
Улбар шар	
Шар	
Улаан	
Ягаан	
Ногоон	
Цагаан	




Зургийг ажиглаад дараах асуултад хариулаарай.

1. Манай орон аль тивд оршдог вэ? Нэрийг бичээрэй.
2. Манай орноос баруун зүгт ямар тивүүд оршиж байна вэ?
3. Африк тив манай орноос аль зүгт оршиж байна вэ?
4. Манай орноос зүүн өмнө зүгт оршдог тивийг нэрлээрэй.
5. Европ тив Африкийн аль зүгт оршиж байна вэ?

Дасгал 3. 56 дугаар хуудасны зургийг ажиглаарай. Хүүхдүүдийн амьдарч байгаа улсыг газрын зурагт олоорой. Олсон улсаа хүснэгтэд нөхөж бичээрэй.

Хүүхдийн нэр	Амьдардаг улс
Анна	
Марк	
Линда	
Малина	
Нора	
Кониши	
Жосиана	
Малек	
Зайяд	



УС БА ХУУРАЙ ГАЗАР




Дэлхийн бөмбөрцөгт усыг цэнхэр өнгөөр тэмдэглэсэн байна.

Тийм байна. Ус их талбайг эзэлж байна.



Дасгал 1. Дэлхий дээр хэдэн далай байна вэ? Эдгээр далай хаана оршиж байна вэ?

Далайн нэр	Хаана оршиж байна вэ?
Атлантын далай	
Номхон далай	
Хойд мөсөн далай	
Энэтхэгийн далай	




Дасгал 2. Хоёр тал бөмбөрцгийн зургийг харьцуулж ажиглаарай. Өгүүлбэрийг нөхөж бичээрэй.

1. Баруун тал бөмбөрцөгт тив байна.
2. Зүүн тал бөмбөрцөгт,,, тив байна.
3. Баруун тал бөмбөрцөгт ус ба хуурай газрын аль нь их талбай эзэлж байна вэ?
4. Зүүн тал бөмбөрцөгт ус ба хуурай газрын аль нь их талбай эзэлж байна вэ?
5. Дэлхий дээр ус ба хуурай газрын аль нь их талбай эзэлж байна вэ?

Дасгал 3. Далай ба хуурай газрыг дүрсэлцгээе.

1. Хааш хаашаа дөрвөлжин 10 нүд зураарай. Нийт хэдэн дөрвөлжин болох вэ?
2. Зурсан дөрвөлжин нүднээс 70 тоолж цэглээд түүнийгээ цэнхрээр будаарай. Хэдэн дөрвөлжин үлдэж байна вэ?
3. Үлдсэн дөрвөлжинг бор өнгөөр будаарай. Хэдэн дөрвөлжин бороор, хэд нь цэнхэр өнгөөр будагдсан бэ? Тоолоорой.
4. Ус ба хуурай газар тус бүр хэдэн дөрвөлжин байгааг тоолоорой. Аль нь их талбай эзэлж байна вэ?



Ус Хуурай газар



Глобус дээрээс дэлхийн гадаргын зөвхөн нэг талыг харна. Нөгөө хагас нь глобусын цаад талд байдаг тул харагдахгүй. Глобусыг хуваасан хоёр тал бөмбөрцгийг цаасан дээр буулгаж дүрсэлсэн зургийг тал бөмбөрцгийн карт гэнэ.

БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Газрын зураг ажиглаад хүснэгтийг нөхөж бичээрэй.

Монгол улсын хойд талд орших улсын нэр	Монгол улсын өмнө талд орших улсын нэр	Монгол улсын баруун талд орших улсын нэр	Монгол улсын зүүн талд орших улсын нэр

2. Чи ямар улсаар аялахыг хүсдэг вэ? Тэр улс орны тухай юу мэддэгээ найздаа ярьж өгөөрэй.

3. Газрын зурагт өндөр уул, тал газар, нам уулсыг ямар өнгөөр дүрсэлсэн байдаг вэ? Дараах дүрсийг будаж тайлбарлаарай.



4. Гол, нуурын нэрийг ангилан бичээрэй.

Онон, Хөвсгөл, Хэрлэн, Увс, Буйр, Орхон

Гол	Нуур

5. Дараах улсын нэрийг уншаарай. Аль тивд байдаг вэ? Зөв харгалзуулан холбоорой.

Улс	Тив
Солонгос	Америк
Канад	Европ
Япон	Ази
Герман	Африк

ХҮН БА ОРЧИН III

Ерөнхий боловсролын сургуулийн
3 дугаар ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:

Гишүүд:

А.Энхтогтох

Е.Батчулуун

Г.Баярмаа

Ө.Болорчимэг

Т.Оюун

Д.Оюунчимэг

Э.Мөнгөнтулга

Р.Нямхүү

У.Туяа

Ц.Пагмасүрэн

С.Цогбадрах

М.Энхбаяр

Редактор:

Техник редактор:

Хэвлэлийн эх бэлтгэгч:

У.Мягмаржав

С.Гэндэнжамц


Х.Балдандорж

Формат 84x108/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м²

Хэвлэлийн хуудас 8 х.х

Хэвлэлийн эхийг “Экимто” ХХК-д бэлтгэж,
“Битпресс” ХХК-д 10000 хувь хэвлэв.



ISBN 978-99973-69-47-5



9 789997 369475